



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар A/203

Бор-Өндөр сум

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/502 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 00⁰¹ цагаас эхлэн 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 00⁰⁰ цаг хүртэлх хугацаанд Бор-Өндөр сумын хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр соёл, урлаг, үзвэр, спорт зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулахыг хориглосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бор-Өндөр сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга (цагдаагийн дэд хурандаа Т.Энхбаяр)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ